

БАНКИЙГ ТОГТВОРЖУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, БАТЛАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Банкны тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт заасан банкнийг тогтворжуулах төлөвлөгөөний бүтэц, агуулгыг тодорхойлж, төлөвлөгөөг батлах, хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Банк тогтворжуулах төлөвлөгөөнд өөрийн үйл ажиллагааны онцлог, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан үүсэж болох эрсдэлийг урьдчилан тооцож, банкны санхүүгийн болон үйл ажиллагааны тасралтгүй байдал, төлбөрийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хадгалахад чиглэсэн хариу арга хэмжээг тусгасан байна.
- 1.3. Банкнийг тогтворжуулах төлөвлөгөөнд тусгасан банкны нэгдэл, түүний толгой компани болон бусад оролцогчид холбогдох хууль эрх зүй, санхүү, үйл ажиллагааны талаарх мэдээлэл нь үнэн зөв, иж бүрэн, цэгцтэй, үнэлж болохуйц тодорхой байна.
- 1.4. Банкнийг тогтворжуулах төлөвлөгөө нь банкны стратеги төлөвлөгөө, бизнес төлөвлөгөө, чанаргүй активыг бууруулах стратеги, зохистой засаглал, үйл ажиллагааны тасралтгүй байдлын төлөвлөгөө, банкны өөрийн хөрөнгө болон төлбөрийн чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх үйл явц, эрсдэлийн удирдлагын бодлого болон эрсдэлийн хэм хэмжээтэй уялдаж, бодитой хэрэгжих боломжтой байна.
- 1.5. Банк төлөвлөгөөний урьдчилан сэргийлэх эрсдэлийн болон төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх түвшинг өөрийн үйл ажиллагааны онцлог, банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг харгалзан, хэвийн үйл ажиллагааны үед зөрчигдөхгүй байх зарчмыг баримтлан, Монголбанкнаас тогтоосон зохистой харьцаа, хязгаарлалтын шалгуур үзүүлэлтээс дээгүүр тогтооно.

ХОЁР. БАНКИЙГ ТОГТВОРЖУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭЦ, БҮРДЭЛ

- 2.1. Банкнийг тогтворжуулах төлөвлөгөө дараах бүрдэлтэй байна. Үүнд:
 - 2.1.1. Банкнийг тогтворжуулах төлөвлөгөөг ашиглах заавар;
 - 2.1.2. Банкнийг тогтворжуулах төлөвлөгөөний бүтэц:
 - 2.1.2.1. Банкны удирдлага, зохион байгуулалт;
 - 2.1.2.2. Банк, банкны нэгдлийн мэдээлэл;
 - 2.1.2.3. Системд ач холбогдол бүхий үйл ажиллагаа, үйлчилгээ;
 - 2.1.2.4. Хүндрэлт нөхцөлийн төсөөлөл;
 - 2.1.2.5. Банкнийг тогтворжуулах арга хэмжээ;
 - 2.1.2.6. Олон нийттэй харилцах стратеги;
 - 2.1.2.7. Төлөвлөгөөний бэлтгэл арга хэмжээ.
 - 2.1.3. Банкнийг тогтворжуулах төлөвлөгөөний дотоод хяналт, баталгаажуулалт, туршилт:
 - 2.1.3.1. Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хяналт;
 - 2.1.3.2. Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны хяналт;

2.1.3.3. Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод аудитын хорооны хяналт.

ГУРАВ. БАНКИЙГ ТОГТВОРЖУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨГ АШИГЛАХ ЗААВАР

- 3.1. Банкнийг тогтворжуулах төлөвлөгөөг ашиглах заавар нь хүндрэлт нөхцөл үүссэн үед банкны төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон бусад холбогдох нэгжийг богино хугацаанд шийдвэр гаргах, хариу арга хэмжээг түргэн шуурхай хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллээр хангах зориулалттай байх бөгөөд энэ хэсэгт дараах мэдээллийг тусгана. Үүнд:
- 3.1.1. Банкнийг тогтворжуулах төлөвлөгөөний заавар болон төлөвлөгөөний хэсэг хоорондын уялдаа холбоо, хамаарал;
 - 3.1.2. Банкны санхүүгийн үзүүлэлтүүд урьдчилан сэргийлэх эрсдэлийн, төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх, нэн хүндрэлт нөхцөлийн түвшин, түүнд хяналт тавих үйл явц, удирдлагын мэдээллийн системтэй уялдуулсан байдал;
 - 3.1.3. Банкны 3.1.2.-т заасан эрсдэлийн түвшин тус бүрт авч хэрэгжүүлэх үе шат бүхий багц арга хэмжээний хураангуй;
 - 3.1.4. Тогтворжуулах арга хэмжээний сонголт, түүнийг хэрэгжүүлэх шийдвэр гаргалт:
 - 3.1.4.1. Банкны удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэр гаргах үйл явц, дараалал, хугацаа, эрх хэмжээ;
 - 3.1.4.2. Хариуцах нэгжийн бүтэц, бүрэлдэхүүн, ажил үүргийн хувиарлалт, үүрэг хариуцлага, гүйцэтгэх ажлын дараалал, хэрэгжүүлэх хугацаа;
 - 3.1.4.3. Тогтворжуулах арга хэмжээний дараалал, санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтэд нөлөөлөх нөлөөлөл, үр дүн, эрсдэл, хэрэгжүүлэх болон үр дүн гарах хугацаа, зардал;
 - 3.1.5. Монголбанк, олон нийт, дотоод газар, нэгжтэй харилцах стратегийн хураангуй;
 - 3.1.6. Төлөвлөгөөний бэлтгэл арга хэмжээний хураангуй;
 - 3.1.7. Банкны онцлогт тохирсон бусад шаардлагатай мэдээлэл.

ДӨРӨВ. БАНКИЙГ ТОГТВОРЖУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1. Банкны удирдлага, зохион байгуулалт

- 4.1.1. Банкнийг тогтворжуулах төлөвлөгөө боловсруулахдаа банкны тухайн чиг үүрэгт харгалзах газар, нэгжийн эрх бүхий албан тушаалтан оролцсон байх шаардлагатай бөгөөд дараах мэдээллийг тусгана. Үүнд:
- 4.1.1.1. Төлөвлөгөөний хэсэг бүрийг боловсруулсан, хэрэгжүүлэх, шинэчлэх газар нэгж, албан тушаалтны мэдээлэл;
 - 4.1.1.2. Төлөвлөгөөг нэгтгэх, хариуцах, холбоо барих албан тушаалтны мэдээлэл.
- 4.1.2. Банкнийг тогтворжуулах төлөвлөгөөнд тусгасан хүндрэлт нөхцөл үүссэн тохиолдолд шийдвэр гаргалтын үйл явц, дарааллын талаар дараах мэдээллийг тусгана. Үүнд:
- 4.1.2.1. Тогтворжуулах арга хэмжээний үед гүйцэтгэх ажлын дараалал;
 - 4.1.2.2. Банкнийг тогтворжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх газар, нэгжийн чиг үүрэг, ажил үүргийн талаарх мэдээлэл;
 - 4.1.2.3. Банкнийг тогтворжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх шийдвэр гаргах хугацаа.
- 4.1.3. Тогтворжуулах төлөвлөгөөний өмнөх хувилбараас шинэчлэгдсэн материаллаг өөрчлөлтийн талаарх товч мэдээлэл.

4.1.4.Банкийг тогтворжуулах төлөвлөгөө нь удирдлагын мэдээллийн системтэй хэрхэн уялдсан талаарх мэдээллийг тусгана.

4.2. Банк, банкны нэгдлийн мэдээлэл

4.2.1.Банк, банкны нэгдлийн мэдээлэлд дараах мэдээллийг тусгана. Үүнд:

- 4.2.1.1. Банк, банкны нэгдлийн бүтэц, бүдүүвч, үйл ажиллагаа, зохион байгуулалт, харилцан хамаарал, эзэмшлийн хувь хэмжээ, оролцогч тус бүрийн эцсийн өмчлөгчийн мэдээлэл;
- 4.2.1.2. Банкны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтын дагуу банк, банкны нэгдлийн бусад оролцогчийн санхүүгийн тайлан болон банкны нэгдлийн нэгдсэн санхүүгийн тайлан болон бусад эрх бүхий байгууллагад илгээсэн тайлан, мэдээлэл;
- 4.2.1.3. Энэ журмын 4.2.1.1-т заасан этгээд хоорондын хамаарал бүхий зээл, эх үүсвэр болон түүнтэй адилтгах актив, эх үүсвэрийн мэдээлэл, төлбөр тооцоо, банканд үзүүлэх нөлөө;
- 4.2.1.4. Банкны бүтэц, зохион байгуулалт, газар, нэгж тус бүрийн чиг үүрэг;
- 4.2.1.5. Банкны үйл ажиллагаа тус бүрийг гүйцэтгэх газар нэгжийн оролцооны мэдээлэл.

4.3. Системд ач холбогдол бүхий үйл ажиллагаа, үйлчилгээ

- 4.3.1.Банкийг тогтворжуулах төлөвлөгөөнд ашиглагдах суурь мэдээллүүд, банкны хувьд системд ач холбогдол бүхий болон банканд ач холбогдол бүхий үйл ажиллагаа, үйлчилгээг тодорхойлж, тэдгээрийг санхүүгийн хүндрэлт нөхцөлийн төсөөллийн үед хэрхэн авч үлдэх, үргэлжлүүлэх цогц арга хэмжээг энэ хэсэгт тусгана.
- 4.3.2.Системд ач холбогдол бүхий үйл ажиллагаа нь тухайн үйл ажиллагаа доголдоход эдийн засгийн бодит сектор болон санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөхүйц, бусад этгээд гүйцэтгэхэд хөрөнгө, хугацаа их шаардагдах үйл ажиллагаа байна.
- 4.3.3.Банканд ач холбогдол бүхий үйл ажиллагаа нь зах зээлд танигдсан, тухайн банкны голлох ашиг, орлогыг бүрдүүлдэг үйл ажиллагаа байна.
- 4.3.4.Систем болон банканд ач холбогдол бүхий үйлчилгээ нь энэ журмын 4.3.2, 4.3.3-т заасан үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангахад чиглэсэн дэмжих үйлчилгээ байна.
- 4.3.5.Банкны системд ач холбогдол бүхий үйл ажиллагаа, үйлчилгээг тодорхойлохдоо Монголбанкнаас гаргасан зааврыг баримтлан тоон үзүүлэлт болон чанарын хүчин зүйлд үндэслэж, тухайн үйл ажиллагааны зах зээлд эзлэх хувь, орлуулах боломж, харилцагчдад болон санхүүгийн салбарт үзүүлэх нөлөөг харгалзана.
- 4.3.6.Системд болон банканд ач холбогдол бүхий гэж тодорхойлогдсон үйл ажиллагаа, үйлчилгээг иж бүрэн, үнэлж болохуйц тайлбар, үндэслэлээр баталгаажуулна.

4.4. Хүндрэлт нөхцөлийн төсөөлөл

- 4.4.1.Хүндрэлт нөхцөлийн төсөөлөл нь системийн болон тухайн банкны хүндрэлтэй нөхцөл байдлын таамаглал байх бөгөөд дараах шинж чанарыг агуулна. Үүнд:
 - 4.4.1.1. Хүндрэлт нөхцөлийн төсөөлөл нь тогтворжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй нөхцөлд банкийг санхүү төлбөрийн чадваргүй байдалд хүргэхүйц хэмжээнд байна.

- 4.4.1.2. Хүндрэлт нөхцөл нь онцгой бөгөөд тохиолдож болохуйц байна.
- 4.4.1.3. Банк хүндрэлт нөхцөлийн төсөөллийн төлбөрийн чадвар болон хөрвөх чадварт үзүүлэх нөлөөллийг тооцно.
- 4.4.2. Банк системийн хэмжээнд болон тухайн банканд үүсч болзошгүй хүндрэлт нөхцөлийн төсөөллийг тодорхойлж, дараах нөхцөлийг хангасан гурваас багагүй хувилбарыг төлөвлөгөөнд тусгана.
 - 4.4.2.1. Санхүүгийн системд болон бодит эдийн засагт ноцтой сөрөг үр дагавар авчрах эрсдэлтэй үйл явдлыг илэрхийлсэн “системийн хэмжээний төсөөлөл”;
 - 4.4.2.2. Томоохон зээлдэгч, банкны нэгдэл, банканд ноцтой сөрөг үр дагавар авчрах эрсдэлтэй үйл явдлыг илэрхийлсэн “өвөрмөц шинжтэй үйл явдлын төсөөлөл”;
 - 4.4.2.3. Энэ журмын 4.4.1.1, 4.4.1.2-т заасан “хосолсон төсөөлөл”.
- 4.4.3. Банк хүндрэлт нөхцөлийн төсөөллийг богино болон урт хугацаагаар боловсруулна.

4.5. Банкийг тогтворжуулах арга хэмжээ

- 4.5.1. Банк хүндрэлт нөхцөлийн үед системд болон банканд ач холбогдол бүхий үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилгоор тогтворжуулах арга хэмжээг төлөвлөх бөгөөд тэдгээр нь дараах шаардлагыг хангахад чиглэнэ. Үүнд:
 - 4.5.1.1. Өөрийн хөрөнгийн хүрэлцээг хангах;
 - 4.5.1.2. Төлбөрийн чадварыг хадгалах;
 - 4.5.1.3. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хадгалах;
 - 4.5.1.4. Эрсдэлийг бууруулах.
- 4.5.2. Банк учирч болзошгүй эрсдэлд тохирсон олон хувилбарт үе шат бүхий багц тогтворжуулах арга хэмжээг урьдчилан сэргийлэх эрсдэлийн, төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх болон нэн хүндрэлт нөхцөлийн түвшин тус бүрт төлөвлөж, төлөвлөгөөнд тусгана.
- 4.5.3. Засгийн газраас аливаа хэлбэрээр дэмжлэг авах, хөнгөлөлт эдлэх тогтворжуулах арга хэмжээг төлөвлөгөөнд тусгахгүй.
- 4.5.4. Монголбанкнаас олгох төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зээлээс бусад аливаа хэлбэрээр дэмжлэг авах, хөнгөлөлт эдлэх, журам зааварт өөрчлөлт оруулах тогтворжуулах арга хэмжээг төлөвлөгөөнд тусгахгүй.
- 4.5.5. Банк төлөвлөгөөнд тусгасан тогтворжуулах арга хэмжээ тус бүрийн нөлөөлөл, хэрэгжихүйц байдлыг үнэлнэ.
- 4.5.6. Тогтворжуулах арга хэмжээний нөлөөллийн үнэлгээ нь банкны санхүүгийн үзүүлэлтүүд, үйл ажиллагаанд болон гуравдагч этгээдэд үзүүлэх нөлөөллийг тооцоолсон үр дүнгийн шинжилгээ байна.
- 4.5.7. Тогтворжуулах арга хэмжээний хэрэгжихүйц байдлын үнэлгээ нь банк тухайн арга хэмжээг хэрэгжүүлж байсан туршлагатай эсэх, хууль эрх зүйн, үйл ажиллагааны, санхүүгийн, нэр хүндийн эрсдэлийн түвшин, хэрэгжүүлэх боломж, хугацаа болон эдгээрийн үр дагаврын талаар хийсэн цогц дүн шинжилгээ байна.
- 4.5.8. Энэ журмын 4.5.6 болон 4.5.7-д заасан эрсдэлийг удирдах, шийдвэрлэх арга хэмжээний дэлгэрэнгүй тайлбарыг тусгана.
- 4.5.9. Банк төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх түвшинд хүрсэн тохиолдолд нэн даруй Монголбанканд мэдэгдэж, төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх бөгөөд хэрэгжилтийн тайланг тухай бүр Монголбанканд хүргүүлнэ.

4.6. Олон нийттэй харилцах стратеги

- 4.6.1. Банк тогтворжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх тохиолдолд олон нийтэд мэдээлэл хүргүүлэх стратегийг боловсруулсан байна.
- 4.6.2. Банк зах зээлд үүсч болзошгүй сөрөг үр дагавраас сэргийлэх зорилгоор олон нийттэй харилцах стратегийг боловсруулахдаа банкны хүрээнд болон олон нийтэд чиглэсэн байна.
- 4.6.3. Олон нийттэй харилцах стратегид хэрэгжүүлэх арга хэмжээ, шийдвэр гаргалтын дэс дараалал зэргийг хугацаа болон хариуцах албан тушаалтны хамт тодорхойлсон байна.

4.7. Төлөвлөгөөний бэлтгэл арга хэмжээ

- 4.7.1. Банк тогтворжуулах төлөвлөгөөг боловсруулах явцад түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд үүсч болзошгүй хүндрэлээс сэргийлэх, хугацаа хэмнэх болон цаашид сайжруулах шаардлагатай урьдчилсан бэлтгэл арга хэмжээг тодорхойлно.
- 4.7.2. Банкны урьдчилсан бэлтгэл арга хэмжээнд хэрэгжүүлэх ажил, хэрэгжилтийн шийдвэр гаргалтын үйл явц зэргийг хугацаа болон хариуцах албан тушаалтны хамт тодорхойлно.

ТАВ. БАНКИЙГ ТОГТВОРЖУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДОТООД ХЯНАЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТ, ТУРШИЛТ

- 5.1. Банкнийг тогтворжуулах төлөвлөгөөг банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо болон Дотоодын аудитын хороо тус тус хянаж, Төлөөлөн удирдах зөвлөл батална.
- 5.2. Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо төлөвлөгөөнд хэрэглэсэн загвар, статистик аргачлал, хүндрэлт нөхцөл байдлын төсөөлөл үндэслэлтэй эсэх, банкны эрсдэлийн удирдлагын бодлого болон бусад холбогдох баримт бичигтэй нийцтэй эсэхийг хянаж, дүгнэлт гаргана.
- 5.3. Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод аудитын хороо дараах хяналтыг хэрэгжүүлж, хараат бус дүгнэлт гаргана. Үүнд:
 - 5.3.1. Банк өмнөх тайлант жилд төлөвлөгөөнд тусгасан аливаа эрсдэлийн түвшинд банкны санхүүгийн үзүүлэлтүүд хүрсэн тохиолдолд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байдал;
 - 5.3.2. Банк өмнөх жилийн төлөвлөгөөнд Монголбанкнаас хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг тусгасан байдал;
 - 5.3.3. Тухайн жилийн төлөвлөгөө нь энэхүү журмын шаардлага хангаж байгаа эсэх;
 - 5.3.4. Банкны туршилтын үйл явцад хяналт тавьж, түүний үр дүнд үндэслэсэн төлөвлөгөөнд оруулах өөрчлөлт, хэрэгжих чадавхийг сайжруулах арга хэмжээг тусгах санал, зөвлөмж.
- 5.4. Банк тогтворжуулах арга хэмжээний бэлэн байдал, үр нөлөөг үнэлэх зорилгоор хүндрэлт нөхцөлийн төсөөлөлд тусгасан нөхцөл байдал тогтоогдсон гэж тооцон тогтворжуулах төлөвлөгөөний хэрэгжилтэд жилд нэгээс доошгүй удаа туршилт хийнэ.
- 5.5. Банк энэ журмын 5.1, 5.2, 5.3, 5.4-т заасан холбогдох нотлох баримт, дүгнэлт, тогтоол, хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг баталгаажуулан Монголбанканд ирүүлнэ.

ЗУРГАА. БАНКИЙГ ТОГТВОРЖУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨГ ТАЙЛАГНАХ

- 6.1. Банк банкнийг тогтворжуулах төлөвлөгөө, түүний бүрдлийг энэхүү журамтай нийцүүлэн дараах хавсралтуудын хамт жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны өдөрт багтаан Монголбанканд бичгээр болон цахим хэлбэрээр ирүүлнэ.
 - 6.1.1. Банкны бүтэц зохион байгуулалтыг 1 дүгээр хавсралтаар;
 - 6.1.2. Банкны салбар, нэгжийн мэдээллийг 2 дугаар хавсралтаар;
 - 6.1.3. Банкны системд болон банканд ач холбогдол бүхий үйл ажиллагааг тодорхойлох мэдээлэл буюу банкны зээлийн мэдээллийг 3а дугаар хавсралтаар, эх үүсвэрийн мэдээллийг 3б дугаар хавсралтаар, тэнцлийн гадуурх мэдээллийг 3в дугаар хавсралтаар;
 - 6.1.4. Тогтворжуулах арга хэмжээний урьдчилан сэргийлэх болон хэрэгжүүлж эхлэх түвшинг 4 дүгээр хавсралтаар;
 - 6.1.5. Хүндрэлт нөхцөлийн төсөөллийн нөлөөлөл болон тогтворжуулах арга хэмжээний үр дүнг 5 дугаар хавсралтаар;
 - 6.1.6. Банкнийг тогтворжуулах арга хэмжээний нөлөөллийг 6 дугаар хавсралтаар;
 - 6.1.7. Банкны системд ач холбогдол бүхий үйл ажиллагаа, үйлчилгээний үнэлгээг 7а, 7б дугаар хавсралтаар.
- 6.2. Монголбанк банкнаас ирүүлсэн төлөвлөгөө, түүний бүрдлийг Банкны тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3 дэх заалтын дагуу шаардлага хангаагүй гэж үзвэл 5 дугаар сарын 15-ны өдрийн дотор бичгээр эсхүл цахим хэлбэрээр банканд мэдэгдэнэ. Банк мэдэгдэл авснаас хойш ажлын 20 хоногийн дотор төлөвлөгөөг шинэчлэн ирүүлнэ.
- 6.3. Банкны бүтэц зохион байгуулалтад тогтворжуулах төлөвлөгөөнд нөлөөлөхүйц хэмжээгээр өөрчлөлт орсон, санхүүгийн болон зохистой харьцааны үзүүлэлтүүд эрс муудсан эсвэл богино хугацаанд муудаж болзошгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд банк тогтворжуулах төлөвлөгөөг нэн даруй шинэчлэн Монголбанканд хүргүүлнэ.

ДОЛОО. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

- 7.1. Монголбанк Банкны тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4 дэх заалтын дагуу банкнаас ирүүлсэн тогтворжуулах төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжтой эсэхэд хяналт тавьж ажиллана.
- 7.2. Монголбанк нь энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж, журмын заалтыг зөрчсөн этгээдэд Банкны тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.